



# **ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ**

---

**2021 оны 41 болон 42 дахь долоо хоног**

---

## ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2021 оны 12-р сарын 08-ны байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас 2 долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 2021 оны 18 дахь дугаарыг хүргэж байна.

### 1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

#### *Дэлхийн эдийн засгийн төлөв*

- Глобал эдийн засаг сэргэж байгаа хэдий ч сэргэлт улс орнуудын хувьд тэнцвэргүй, өсөлтийн төлөв өмнөх улирлын төсөөллөөс муудаад байна. КОВИД-19-ийн эсрэг вакцинжуулалт үргэлжилж, хөл хорио сулран, дэлхийн эдийн засаг 2021 оны 3-р улиралд 12.2 хувиар<sup>1</sup> сэргэсэн ч цар тахлын нөхцөл байдал, нийлүүлэлтийн доголдоос шалтгаалан өсөлтийн момент буурах тал руу хэлбийж, энэ онд 5.6 хувиар (өмнөх улирлын төсөөллөөс 0.3 нэгж хувиар бага), ирэх онд 4.3 хувиар өсөх төлөвтэй байна (Хүснэгт 1). Тухайлбал, энэ оны эхээр ажиглагдсан эдийн засгийн огцом идэвхжил нь дийлэнх хөгжингүй эдийн засаг болон БНХАУ-д эрчээ алдаж эхэллээ. БНХАУ-д үл хөдлөх хөрөнгийн захын нөхцөл байдал муудсан, Тэг-

КОВИД-19-ийн бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь зарим бүс нутгийн хэрэглээ, аж үйлдвэрлэл, тээвэр, логистикт сөргөөр нөлөөлж байна. Мөн АНУ, Евро бүсэд 4-р улиралд дельта вирусын тархалт нэмэгдэн, эрэлт саарч, үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэнээр аж үйлдвэрлэлийн өсөлт удаашрах төлөвтэй болсныг статистик мэдээллээс харж болохоор байна. АНУ-ын борлуулалтын менежерүүдийн индекс 11-р сард 58.3 гарсан нь сүүлийн 12 сарын хамгийн бага тэлэлт бол Евро бүсийн хувьд борлуулалтын менежерүүдийн индекс 11-р сард 55.4 гарсан нь өмнөх сараас сайжирсан үзүүлэлт боловч бүсийн 2 том эдийн засгийн хувьд мууджээ.

**Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд**

Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	2021 он					2022 он
		Дэлхийн эдийн засгийн өсөлт	БНХАУ-ын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт	Дэлхийн эдийн засгийн өсөлт

<sup>1</sup> ОУВС болон Haver analytics байгууллагын тооцоо

1	ОУВС	10/12/2021	<b>5.9%</b>	8.0%	6.0%	5.0%	4.7%	<b>4.9%</b>
2	The EIU	10/19/2021	<b>5.4%</b>	7.9%	5.7%	4.8%	3.8%	<b>4.1%</b>
3	Euro Monitor	11/20/2021	<b>5.7%</b>	8.0%	5.5%	5.0%		<b>4.6%</b>
4	IHS Markit	11/23/2021	<b>5.5%</b>	8.1%	5.5%	5.1%		<b>4.2%</b>
6	S&P global	11/30/2021	<b>5.7%</b>	8.0%	5.5%	5.1%	4.2%	<b>4.2%</b>
7	OECD	12/01/2021	<b>5.6%</b>	8.1%	5.6%	5.2%	4.3%	<b>4.5%</b>
	<b>Дундаж</b>		<b>5.6%</b>	8.0%	5.6%	5.1%	4.1%	<b>4.3%</b>

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

- Ирэх онд хөл хорио үргэлжлэн сулрах, эдийн засаг сэргэсэн суурь үеийн нөлөө арилах, нийлүүлэлтийн хязгаарлалтууд багасах, эрчим хүчний үнэ буурах хүлээлттэй. Мөн вакцинжуулалтын хувь нэмэгдэж, цар тахлын эмчилгээ илүү үр дүнтэй болох, бизнесүүд цар тахалтай орчинд илүү дасан зохицох, хэрэглээ бараа бүтээгдэхүүнээс үйлчилгээ рүү шилжиж цар тахлын өмнөх тэнцвэрт түвшин рүү дөхөх зэргээр цар тахалтай холбоотой өсөлтийн хязгаарлалтууд буурахаар байна. Улмаар хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил, иргэдийн өндөр хадгаламж, санхүүгийн зах зээлийн таатай төлөв байдал, үйлчилгээний салбарын сэргэлт зэрэг нь ирэх оны эдийн засгийн өсөлтийг тэтгэхээр байна.
- Хэдийгээр цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө буураад байгаа хэдий ч дэлхийн эдийн засгийн төлөв КОВИД-19-ийн нөхцөл байдал, вирусын шинэ аюултай хувилбарууд, түүний хор хөнөөлтэй байдлаас ихээхэн хамаарахаар байна. Сүүлийн сард зарим бүс нутагт цар тахлын тархалт эрчтэй нэмэгдэж буй нь вакцинжуулалтын явц бага байгаа улс орнуудыг эргэн хөл хориог чангатгахад хүргэж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй боллоо. Мөн ихэнх улс орнуудад инфляц эрчтэй нэмэгдсэн тул Төв банкууд инфляцыг буулгах арга хэмжээ хүлээлтээс эрт авах, улмаар эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

### Олон улсын тээвэр

- Улс орнууд эдийн засгаа нээж эхэлснээс хойш (2021 оны 2-р улирлаас) бараа бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэхэд нийлүүлэлт эрэлтийг даган хурдацтай сэргэж чадаагүйгээс үйлдвэрлэлийн гинжин сүлжээнд доголдол бий болсон. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн нийлүүлэлтийн тал түүхий эд, орцын хомсдол, тээвэр, логистикийн хязгаарлалт, түгжрэл болон ажиллах хүчний дутагдлаас шалтгаалан эрэлтийг гүйцэж чадахгүй хэвээр байна. Freightos байгууллагаас тооцож зарладаг “Дэлхийн контейнер тээврийн нэгдсэн индекс” 2021 оны 9-р сард хамгийн өндөр буюу 40 инчийн контейнер тээврийн үнэ 10,839 ам.доллар хүрсэн бол 10-р сард 10,194 ам.доллар, 11-р сард 9,353 ам.доллар болж бага зэрэг буураад байгаа ч энэ нь өмнөх оны мөн үеэс 3.8 дахин өндөр дүн юм.

### Гадаад инфляцын төлөв

- Эрэлт нэмэгдсэн ч ажиллах хүчний хомсдол, цар тахалтай холбоотой хөл хорио, хязгаарлалтуудаас шалтгаалан нийлүүлэлт хурдацтай сэргэж чадаагүйгээс эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал бий болсон. Түүнчлэн нийлүүлэлтийн доголдол, түүхий эдийн өндөр үнэ, хүнсний үнийн өсөлтөөс үүдэлтэй зардлын дарамтаас гадна эрчим хүчний зах зээлийн тэнцвэргүй байдал нь олон оронд инфляц мэдэгдэхүйц өсөхөд нөлөөллөө. Тухайлбал, 2021 оны 11-р сард ХҮИ-ээр



хэмжигдэх инфляцын түвшин АНУ-д 6.1 хувь, Евро бүсэд урьдчилсан тооцоогоор 4.9 хувь, ОХУ-д 10-р сарын байдлаар 8.1 хувь байгаа нь Төв банкуудын инфляцын зорилтот түвшнээс хэт давсан үзүүлэлтүүд юм. Инфляцын дарамт хэдхэн сарын өмнө хүлээгдэж байснаас илүү хүчтэй, ужгирсан болж байгаа нь эргээд хүлээлтээр дамжин инфляц өндөр хадгалагдахад нөлөөлж болзошгүй байна.

- Ирэх онд үйлдвэрлэлийн үндсэн саад бэрхшээлүүд хөнгөрч, хүчин чадал нэмэгдэж, илүү олон хүн ажиллах хүчинд эргэн ирж, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт байдал нэмэгдэхийн хэрээр инфляц буурах төлөвтэй байна. Гэвч КОВИД-19-ийн халдварын шинэ давалгаанууд гарах тохиолдолд нийлүүлэлт доголдож, энэ нь инфляц буурах хугацааг хойшлуулж болзошгүй.

#### *Гадаад хүүний төлөв*

- АНУ-ын Холбооны нөөцийн банк 2021 оны 11-р сард бодлогын хүүгээ 0.0-0.25%-д хэвээр хадгалах, харин сар тутам бонд худалдан авах дүнгээ алгуур бууруулахаар шийдвэрлэв. Тухайлбал, эдийн засгийн нөхцөл байдал сайжирч байгаа тул ХНБ-аас өмнөх саруудад сар бүр 80 тэрбум ам.долларын ЗГҮЦ, 40 тэрбум ам.долларын ипотека барьцаалсан үнэт цаас худалдан авч байсан бол 11-р сард уг хэмжээг 70 тэрбум ам.доллар, 35 тэрбум ам.доллар болгож тус тус бууруулах, 12-р сард 60 тэрбум ам.доллар, 30 тэрбум ам.доллар болгож бууруулахаар шийдэв. Цаашид Холбооны нөөцийн банк АНУ-ын хөдөлмөрийн зах зээл урт хугацааны бүрэн ажил эрхлэлтийн түвшинд хүрэх болон инфляц 2 хувийн зорилтот түвшин хангагдах хүртэл бодлогын хүүгээ тэг орчим хувьд хадгалахаа мэдэгдэв. Ингэхдээ Төв банк инфляцыг тодорхой хугацаанд зорилтот түвшнээс

бага зэрэг өндөрт байхыг зөвшөөрнө гэж мэдэгдлээ. ХНБ бодлогын хүүг 2023 оноос өсгөх хүлээлттэй байсан бол 2022 оны дундаас өсгөнө гэж шинжээчид хүлээж байна.

- Эрчимтэй хөгжиж буй орнуудад эрчим хүчний үнийн өсөлтийг даган инфляц сүүлийн саруудад эрчимжиж байгаагаас Бразил, Чили, Колумб, Мексик, ОХУ, Польш, Өмнөд Африкийн төв банкууд сүүлийн бодлогын шийдвэрээр бодлогын хүүгээ өсгөсөн бөгөөд ирэх онд бодлогын төлөвийг үргэлжлүүлэн чангаруулах хүлээлттэй байна. Түүнчлэн, Норвеги, БНСУ, Шинэ Зеланд зэрэг хөгжсөн орнуудын Төв банкууд бодлогын хүүгээ сүүлийн хурлаараа өсгөсөн бол Австрали, Их Британи, Шведийн Төв банкууд хөрөнгө худалдан авах хэмжээгээ бууруулаад байна.
- Ийнхүү Төв банкууд хүүгээ өсгөж эхлэх хугацаа ихэнх эрчимтэй хөгжиж буй орнууд гадаад өрөө дахин санхүүжүүлэх шаардлагатай давхцахаар байгаа нь хөгжиж буй орнуудын гадаад **санхүүжилтийн зардал өсөх**, өрсөлдөөн нэмэгдэхийг илтгэж байна.

#### *Онцлох сэдэв: Туркийн лирагийн хямралын тухай*

- Турк Улсад хэвийн бус ханшийн хямрал өрнөж байна. Туркийн лира 11-р сарын 30-ны байдлаар сарын эхнээс ам.долларын эсрэг 34 хувиар суларчээ. Гэхдээ ханш суларсан шалтгаан нь энэ удаад эдийн засгийн суурь нөхцлөөс шалтгаалаагүйгээрээ өмнөх лирагийн ханшийн хямралуудаас ялгаатай байна. Турк улс удаан хугацаанд урсгал тэнцлийн алдагдалтай байсан бол энэ оны 9-р сараас эхлэн аялал жуулчлал нь сэргэж, урсгал тэнцлийн ашигтай болсон буюу суурь хүчин зүйлс ханш чангарах чиглэлд нөлөөтэй байна. Харин лира суларсан нь Турк Улсын Ерөнхийлөгч



Тайп Эрдоган болон түүний Төв банкны бодлогын шийдвэрт нөлөөлсөнтэй холбоотой гэж шинжээчид үзжээ.

- Ерөнхийлөгч Эрдоган энэ оны 3-р сард Төв банкны Ерөнхийлөгч Наци Акбалыг огцруулсан нь сүүлийн 2 жилд 3 дахь Төв банкны Ерөнхийлөгчийг огцруулж буй шийдвэр юм. Улмаар Сахап Кавчиоклуг Төв банкны Ерөнхийлөгчөөр томилсны дараа Туркийн лирагийн ханш даруй 15 хувиар суларч, үүний дараа тодорхой хэмжээнд эргэн чангараад байсан юм. Харин 11-р сард Төв банк инфляц 20 хувь байгааг үл харгалзан бодлогын хүүг 2 нэгж хувиар (энэ ондоо 3 дахь удаагаа) бууруулж, 16 хувьд хүргэх шийдвэр гаргасан нь лирагийн ханш сулрахад хүргэв. Хэдийгээр өмнөх ханшийн хямралуудын үед Ерөнхийлөгч Эрдоган Төв банкныг удаа дараа бодлогын хүүг өсгөхийг зөвшөөрч байсан ч 2023 оны сонгууль дөхсөн тул энэ удаад бага хүүний бодлогоосоо ухрахгүй гэж шинжээчид үзэж байна. Тэрээр өөрийн

#### Эх сурвалж:

1. OECD, [OECD Economic Outlook sees recovery continuing but warns of growing imbalances and risks](#)
2. S&P Global Rating, [Economic Outlook Q1 2022: Rising Inflation Fears Overshadow A Robust Rebound](#)
3. IHS markit, [Global economic growth, inflation will slow in 2022](#)
4. Turkiye Cumhuriyet Merkez Bankasi, [Summary of the Monetary Policy Committee Meeting \(2021-52\)](#)
5. Euporean Commission, [Autumn 2021 Economic Forecast: From recovery to expansion, amid headwinds](#)
6. Mining.com, [Copper price down on omicron uncertainty](#)

байр сууриа баталгаажуулж мэдэгдэл хийхдээ инфляцаас бага хүү буюу бодит хүүний түвшин сөрөг байгаа нь эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалтыг татах, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжих эерэг нөлөөтэй гэж тайлбарлажээ. Гэсэн хэдий ч Туркийн макро эдийн засаг ийнхүү тогтворгүй байгаа үед хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулахаас болгоомжилно гэж шинжээчид таамаглаж байна. Мөн Төв банк бодлогын хүүгээ үргэлжлүүлэн буулгах тохиолдолд лирагийн ханш улам сулрах эрсдэлтэй. Ийнхүү ханш сулрах нь иргэдийн бодит худалдан авах чадварыг огцом бууруулаад зогсохгүй инфляцыг улам хөөрөгдөх нөхцөлийг бүрдүүлээд байна. Улмаар ханшийн хямрал нь Туркийн дундаж орлоготой давхаргыг ядууруулж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж байгааг шинжээчид анхааруулав. Туркийн ард иргэд сүүлийн 7 хоногт эрх баригчдын эдийн засгийн бодлогын шийдвэрийг эсэргүүцэн жагсаж байна.

7. Mining.com, [Iron ore price surges on hopes of increased steel production](#)
8. Hindustan Times, [Gold prices fall to lowest in nearly 6 months, silver down too](#)
9. IMF, [World Economic Outlook – October-2021](#)
10. The Sydney Morning Herald, [The China Evergrande crisis is coming to a head](#)
11. S&P Global Platts, [China's manufacturing PMI rebounds in Nov, but outlook remains sluggish](#)
12. Euromonitor International, [Global Economic Forecasts: Q4 2021](#)
13. Financial Times, [Turkey's currency crisis is of Erdogan's making](#)
14. The Economist, [The response was swift, and the response was brutal"—Turkey's currency spiral](#)

## 2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

*Эдийн засгийн голлох индексүүдийн өөрчлөлт*

- **2021 оны 9, 10-р сард тус тус 49.2, 49.6 байсан БНХАУ-ын боловсруулах салбарын борлуулалтын менежерүүдийн индекс 11-р сард 50.1 болж нэмэгдэв <sup>2</sup> . Эрчим хүчний хомстол багасч, түүхий эдийн үнэ буурсан нь үйлдвэрлэгчдийн зардлыг бууруулж боловсруулах салбар ийнхүү сайжирлаа. Гэвч шинээр авсан захиалгын тоо 4 сар дараалан буурсан, экспортын бүтээгдэхүүний захиалгын тоо 7 сар дараалан буурсан нь эрэлт агшиж байгааг илтгэж, цаашид тус улсын эдийн засаг төдийлөн өндөр өсөхгүй гэсэн дохио болж байна.**
- **БНХАУ-ын ерөнхий сайд Ли Кэчян “БНХАУ-ын эдийн засаг удаашрах хүлээлттэй байгаа талаар дурдаад, цаашид бодлого боловсруулагчид зөвхөн нэг талын бодлого хэрэгжүүлэхээс зайлсхийх шаардлагатай” хэмээв. БНХАУ-ын боловсруулахаас бусад салбарын борлуулалтын менежерийн индекс 10-р сард 52.4 байснаас КОВИД-19 цар тахлын эсрэг хөл хорио тогтоосноос шалтгаалж 11-р сард 52.3 болж удаашрав.**
- **Орцын үнийг бууруулах засгийн газрын бодлогын нөлөөгөөр түүхий эдийн үнэ буурч байгаагаас орцын үнийн индекс 10-р сард 72.1 байснаас 11-р сард 52.9 болж буурлаа.**
- **БНХАУ-ын Төрийн зөвлөлийн 10-р сарын 8-ны хурлаар иргэд, хөдөө аж ахуй, төрийн байгууллагуудын**

**цахилгааны үнийг тогтвортой хадгалж, бусад аж ахуй нэгжүүдийн эрчим хүчний үнийг 20 хүртэл хувиар нэмэгдүүлж болох шийдвэр гаргав <sup>3</sup> . Энэхүү шийдвэр нь үнийн өсөлт нэмэгдэж байгаа энэ үед цахилгаан станцуудын ашгийг нэмэгдүүлэх, мөн эрчим хүчний нийлүүлэлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.**

- **Эверграндын одоогийн санхүүгийн нөхцөл байдлаас харвал цаашид өр төлбөрөө төлж чадахааргүй нөхцөлд байна. БНХАУ-ын үл хөдлөх салбарын том групп Эвергранд өмнө нь зээлийн төлөлтөө хийхдээ хугацаанаасаа удаа дараа хоцорч, эргэн төлөлтөө 30 хоногоор хойшлуулан төлж байсан бол өнгөрсөн баасан гарагт буюу 12-р сарын 3-ны өдөр Эверграндаас дахин 250 сая ам.долларын өр төлөхыг шаардсан ч төлж чадах эсэх нь тодорхойгүй байна. Түүнчлэн, үүсгэн байгуулагч Хуй Ка Ян өөрийн хөрөнгө, хувьцаанаас зарж компанийн төлбөр төлөх чадварыг нэмэгдүүлэх оролдлогыг хийж байна.**
- **Өнгөрсөн баасан гарагт Гуандун мужийн захирагч Эверграндын үүсгэн байгуулагч Хуй Ка Яныг дуудаж цаашид компанийн эрсдэлийн менежментийг хянаж, цаашдын үйл ажиллагааг хэвийн хангахын тулд дотоод хяналтаа чангатгахыг шаардав. Энэ нь БНХАУ-ын засгийн газрын зүгээс эрсдэлийг бууруулж нийгмийн тогтвортой байдлыг хангахаар ажиллаж байгааг илтгэж байна гэж шинжээчид**

<sup>2</sup> Энэхүү индекс нь 50-с бага байх нь эдийн засаг агшиж байгааг илтгэнэ.

<sup>3</sup> Өмнө нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн үнээс 10 хүртэл хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргаж байсан.

үзэж байна. БНХАУ-ын Ардын банкнаас бусад секторт томоохон үл хөдлөх корпорациудын уналт нөлөөлөхгүй байх

*Түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлт (Коксжих нүүрсний зах зээл)*

- Коксжих нүүрсний эрэлт бага байснаар коксжих нүүрсний үнэ 8 удаа буюу нийт 1600 юаниар буураад байна. Тухайлбал, 11 дүгээр сарын 26-ны байдлаар Хэбэй мужид 1 тонн коксжих нүүрсний үнэ 2660 юань буюу 417.2 орчим ам.долларт, Шанси мужид 2460 юань буюу 385.9 орчим ам.долларт хүрч буурчээ. Боомтуудын хувьд нүүрсний зах зээл төдийлөн сэргэхгүй гэсэн сөрөг хандлага давамгайлж, нүүрсний үнэ мөн буурч байна. Тяньжин боомтын нүүрсний үнэ өмнөх 7 хоноогоос 150 юаниар буурч 2700 юань буюу 423.5 орчим ам.долларт хүрчээ.
- Нүүрсний үнэ ийнхүү унаснаар эрэлт нь ялимгүй нэмэгдэж, нүүрсний үйлдвэрүүдийн нөөц 0.17 сая тонноор өмнөх 7 хоноогоос буурч 1.53 сая тоннд хүрч (+153.1% YOY), үнэ бага түвшинд хадгалагдав. Гангийн үйлдвэрүүдийн нүүрсний нөөц өмнөх 7 хоноогоос 0.02 сая тонн буюу 9.8 хувиар нэмэгдэж 6.8 сая тоннд (-23% YOY) хүрлээ.
- Коксжих нүүрсний үнэ буурснаас шалтгаалж нүүрсний үйлдвэрүүдийн ашиг буурч байна. Зарим коксжих нүүрсний үйлдвэрүүд олборлолтоо бууруулж, өндөр зардал бүхий нүүрсний нөөц буурч байгаа нь нүүрсний үйлдвэрүүдийн агуулах болон үйл ажиллагааны дарамтыг бууруулж байна. Гэвч коксжих нүүрсний нийлүүлэлт эрэлтээс өндөр байх нь үнийн төсөөлөл бага байхад нөлөөлөхөөр байна.

нь чухал гэж үзэж байгаа бөгөөд цаашдын томоохон сорилт болохоор байна.

- БНХАУ-ын өвлийн олимп ойртож байгаагаас байгаль, хүрээлэн буй орчны шалгалт эрчимжиж, гангийн үйлдвэрийн хязгаарлалт чанга хэвээр байна. Мөн улирлын чанартай гангийн нийлүүлэлт буурахаар байгаагаас цаашид коксжих нүүрсний эрэлт буурч, үнэ унах төлөвтэй байна.

*Монголын нүүрсний импорт*

- Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрсэн ачааны машины хоногийн дундаж тоо 11-р сарын сүүлийн байдлаар 514-тэй байв. Гэвч 12-р сарын 3-наас эхлэн тус боомтоор нэвтрэх ачааны машины хоногийн дундаж тоо эргэн буурч 100 орчимд хүрээд байна. Богинын төмөр замын тээврийн үнэ нэмэгдэж байгаагаас шалтгаалж Монголын нүүрсний үнэ өндөр хэвээр хадгалагдлаа. Sxcoal байгууллагын мэдээлснээр Гашуунсухайт-Ганцмод боомтын 1 тонн нүүрсний үнэ өмнөх 7 хоноогоос 10 юаниар нэмэгдэж 1310 юань буюу 205.5 орчим ам.долларт хүрэв.
- Шивээхүрэн-Сэхэ боомт хаалттай хэвээр байгаа бөгөөд нүүрсний үнийн мэдээлэл авахад хомс байна. Тус боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх 7 хоноогоос өөрчлөгдөөгүй, 1550 юань буюу 243.1 орчим ам.доллар хэвээр хадгалагдав.

**Эх сурвалж:**

1. *SX Coal, Weekly Update, Monday 29<sup>th</sup> Nov, 2021*
2. *Economist Intelligence Unit, 1<sup>st</sup> November, 2021, Country report: China*

3

**МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ**

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ (\$) 2021/11/30	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоногийн	сарын	оны эхнээс	жилийн	
<b>Зэсийн үнэ</b>	9,442.5	-1.4%	-2.8%	-0.6%	20.1%	24.6%	Зэсийн үнэ 11-р сарын 30-ны байдлаар 9442.5 долларт хүрэв. КОВИД-19 цар тахлын Омикрон хувилбар зарим улс оронд тархснаар, зах зээлийн тодорхой бус байдал нэмэгдэж зэсийн үнэ ийнхүү буурав.
<b>Төмрийн хүдрийн үнэ</b>	94.97	0.3%	1.0%	-21.7%	-42.1%	-23.8%	Төмрийн хүдрийн нийлүүлэлт төдийлөн өөрчлөгдөөгүй байхад БНХАУ-ын гангийн үйлдвэр 12-р сард нэмэгдэх хүлээлтээс шалтгаалж төмрийн хүдрийн үнэ ялимгүй нэмэгдэж 95 долларт хүрэв. БНХАУ энэ оны эхний 10 сард гангийн үйлдвэрлэлээ 2020 оноос бага түвшинд хадгалсан нь үлдсэн саруудад гангийн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх орон зай олгож байна
<b>Алтны үнэ</b>	1774.5	-0.6%	-0.8%	-0.5%	-6.5%	-0.1%	11-р сарын 30-ны байдлаар алтны үнэ 1774.5 долларт хүрч буурав. ХНБ-аас инфляцын түвшин огцом нэмэгдсэн энэ үед мөнгөний нийлүүлэлтгээ бууруулах бодлогоо зарлах (target announcement) хүлээлт үүсч, алтны үнэ ийнхүү буурав.





<p><b>Газрын тосны үнэ (Брент)</b></p>	70.57	-3.9%	-14.3%	-16.4%	38.1%	48.3%	<p>Газрын тосны үнэ 70.6 долларт хүрсэн нь 2020 оны 3 дугаар сараас хойш сарын уналт хамгийн өндөр түвшинд хүрсэн тохиолдол боллоо. КОВИД-19 цар тахлын шинэ хувилбар тархсан, АНУ-ын зүгээс нөөцөөсөө газрын тос нийлүүлэхээр болсон зэрэг нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөлөв. ОПЕК+ зүгээс цаашид ямар арга хэмжээ авах нь хараахан тодорхой бус байна.</p>
--	-------	-------	--------	--------	-------	-------	---